



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

Хүнсний аюулгүй байдлын хяналтын хуудас батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх шинээр боловсруулсан 1.5.2. "Шар айраг, дарсны үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас", 1.10.2. "Гадна талбай, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгт хоол, хүнс бэлтгэх, борлуулах үйлчилгээний газрыг шалгах хяналтын хуудас"-ыг нэгдүгээр хавсралтаар, шинэчлэн боловсруулсан 1.2, 1.3, 1.4, 1.5.1, 1.6, 1.7, 1.8, 1.9, 1.10.1, 1.11, 1.19, 1.20, 1.22, 1.29, 1.30 хяналтын хуудсуудыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан хяналтын хуудсуудыг хяналт шалгалтад хэрэглэх, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын газар, Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газар, Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтын хуудас шинэчлэн баталсантай холбогдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2015 оны "Хяналтын хуудас батлах тухай" 540 тоот тушаалын 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 1.10, 1.11, 1.19, 1.20, 1.22, 1.29, 1.30 кодтой хяналтын хуудсуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Хяналтын хуудасны ашиглалт, хяналт шалгалтын явц, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ хийсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар /М.Наранбат/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ЦАГААНХҮҮ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын
2017 оны 02 дугаар сарын 24 ны өдрийн
1185 тоот тушаалын нэгдүгээр хавсралт




ШИНЭЭР БОЛОВСРУУЛСАН ХЯНАЛТЫН ХУУДАС

№	Хяналтын хуудасны код	Хяналтын хуудасны нэр	тоо
1	1.5.2	Шар айраг, дарсны үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
2	1.10.2	Гадна талбай, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгт хоол, хүнс бэлтгэх, борлуулах үйлчилгээний газрыг шалгах хяналтын хуудас	1
Нийт хяналтын хуудасны тоо			2

оо0оо

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын
2017 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн
А/35 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ХЯНАЛТЫН ХУУДАС

№	Хяналтын хуудасны код	Хяналтын хуудасны нэр	тоо
1	1.2	Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
2	1.3	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
3	1.4	Кремт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
4	1.5.1	Согтууруулах ундаа /спирт, архи/-ны үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
5	1.6	Жүүс, ундааны үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
6	1.7	Гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
7	1.8	Нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
8	1.9	Зайрмагны үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
9	1.10.1	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг шалгах хяналтын хуудас	1
10	1.11	Худалдаалах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
11	1.19	Гурилын үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
12	1.20	Ус, рашааны үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
13	1.22	Ургамлын гаралтай жижиглэн савлагаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас	1
14	1.29	Махны үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас	1
15	1.30	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх хяналтын хуудас	1
Нийт хяналтын хуудасны тоо			15